



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Санхүүгийн зохицуулах хорооны даргын төсвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: САГ-2021/15/СТА-ТЭЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Улаанбаатар хот 2021 он</p>	<p>Монгол Улсын Ерөнхий аудиторовын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 51-261663 Цахим хаяг: <a href="mailto:naranchimegts@audit.gov.mn">naranchimegts@audit.gov.mn</a></p> <p>Аудитын дөрөвдүгээр газрын захирал, тэргүүлэх аудитор: Я.Самбууням Утас: 51-260949 Цахим хаяг: <a href="mailto:sambuunyamyam@audit.gov.mn">sambuunyamyam@audit.gov.mn</a></p> <p>Аудитын менежер: С.Нацагдорж Утас: 51-261885 Цахим хаяг: <a href="mailto:natsagdorjs@audit.gov.mn">natsagdorjs@audit.gov.mn</a></p> <p>Аудитор: Л.Мөнхцацрал Утас: 51-261740 Цахим хаяг: <a href="mailto:munkhtsatsrall@audit.gov.mn">munkhtsatsrall@audit.gov.mn</a></p>
---	--

## Агуулга

1.Аудитын санал дүгнэлт .....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
3. Аудитын тайлан.....	11
3.1 Ерөнхий зүйл.....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, түүний хүлээн зөвшөөрөхүйц байдал....	12
3.4 Материаллаг байдал .....	12
3.5 Санхүүгийн тайлангийн үзүүлэлт .....	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	15
3.8 Аудитын гол асуудал .....	15
3.9 Шилэн дансны мэдээлэл.....	16
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	16
3.11 Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд .....	16
3.12. Аудитын илрүүлэлт .....	17
<b>Залруулсан алдаа .....</b>	<b>17</b>
<b>Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил .....</b>	<b>17</b>
<b>Аудитын зөвлөмж .....</b>	<b>18</b>
<b>4. Менежментийн захидал.....</b>	<b>19</b>
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	22

**Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
САГ	Санхүүгийн аудитын газар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ХК	Хувьцаат компани

---

## 1.Аудитын санал дүгнэлт



### МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ  
ХОРООНЫ ДАРГА Д.БАЯРСАЙХАН  
ТАНАА

2021.04.26 № 1316  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т  
Аудитын санал дүгнэлт

### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Санхүүгийн зохицуулах хорооны даргын төсвийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Санхүүгийн зохицуулах хорооны даргын төсвийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.



Д.ЗАНДАНБАТ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

*/мянган төгрөгөөр/*

Код:	Тайлангийн үзүүлэлт	2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	523,281.8	426,685.0
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	14,511.5	19,902.3
33	АВЛАГА	77,276.7	7,178.3
34	УРЬДЧИЛГАА	310,570.5	200,607.5
35	БАРАА МАТЕРИАЛ	120,923.2	198,997.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,253,420.4	1,397,577.4
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,253,420.4	1,397,577.4
39200	Биет хөрөнгө	825,283.7	1,054,256.0
39300	Биет бус хөрөнгө	428,136.7	343,321.4
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1,776,702.3</b>	<b>1,824,262.4</b>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	2,278.0	1,857.6
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,278.0	1,857.6
41300	Өглөг	2,278.0	1,857.6
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,774,424.3	1,822,404.8
51	Засгийн газрын хувь оролцоо	1,774,424.3	1,822,404.8
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	590,228.9	590,228.9
51200	Хуримтлагдсан үр дүн	1,184,195.4	1,232,175.9
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,776,702.3</b>	<b>1,824,262.4</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>5,565,247.5</b>	<b>5,349,707.0</b>
<b>11</b>	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>64,211.0</b>	<b>40,359.8</b>
118	Бусад татвар, төлбөр, хураамж	-	40,359.8
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>2,557,278.9</b>	<b>2,451,343.2</b>
120	Нийтлэг татварын бус орлого	2,557,278.9	2,451,343.2
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,943,757.6</b>	<b>2,858,004.0</b>
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>5,583,599.6</b>	<b>5,321,992.3</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>5,583,599.6</b>	<b>5,321,992.3</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>3,807,979.7</b>	<b>4,222,444.5</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,186,998.7	2,740,628.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	275,629.4	355,477.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	91,665.0	92,526.0
2104	Хангамж, бараа материалын зардал	80,355.8	75,755.2
2105	Нормативт зардал	-	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	24,324.3	40,222.4
2107	Томилолт, зочны зардал	298,631.7	49,102.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	712,985.8	712,584.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	137,388.9	156,148.9
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,775,620.0</b>	<b>1,099,547.8</b>
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>(18,352.1)</b>	<b>27,714.7</b>
<b>V</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>-</b>	<b>19,734.2</b>
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>(18,352.1)</b>	<b>7,980.5</b>

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
<b>1</b>	<b>2018 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>1,762,776.4</b>	-	<b>1,762,776.4</b>
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	30,000.0	-	30,000.0
<b>3</b>	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>1,792,776.4</b>	-	<b>1,792,776.4</b>
9	Тайлант үеийн үр дүн	(18,352.1)	-	(18,352.1)
<b>10</b>	<b>2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>1,774,424.3</b>	-	<b>1,774,424.3</b>
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	40,000.0	-	40,000.0
<b>13</b>	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>1,814,424.3</b>	-	<b>1,814,424.3</b>
19	Тайлант үеийн үр дүн	7,980.5	-	7,980.5
<b>20</b>	<b>2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>1,822,404.8</b>	-	<b>1,822,404.8</b>

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	5,616,516.8	5,401,435.8
11	ТАТВАРЫН ОРЛОГО	64,221.0	40,359.8
118	Бусад татвар, төлбөр, хураамж	64,221.0	40,359.8
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	64,221.0	40,359.8
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,114,839.5	2,168,412.8
120	Нийтлэг татварын бус орлого	2,114,839.5	2,168,412.8
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,437,456.2	3,192,663.2
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,619,207.5	5,108,714.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,619,207.5	5,108,714.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,779,880.5	3,998,804.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,108,601.3	2,661,444.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	257,933.6	372,823.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	91,665.0	92,526.0
2104	Хангамж, бараа материалын зардал	73,673.4	72,095.1
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	53,554.3	1,020.4
2107	Томилолт, зочны зардал	285,711.8	48,420.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	908,741.0	744,824.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	5,650.3
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,839,327.1	1,109,909.7
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	(2,690.8)	292,721.7
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	37,598.9	287,330.9
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	37,598.9	287,330.9
2200	Дотоод эх үүсвэрээр	37,598.9	287,330.9
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(37,598.9)	(287,330.9)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	(40,289.6)	5,390.8
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	54,801.1	14,511.5
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	14,511.5	19,902.3



## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>4,567,544,800.00</b>	<b>4,269,285,673.14</b>	<b>298,259,126.86</b>	<b>93.5</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>4,567,544,800.00</b>	<b>4,269,285,673.14</b>	<b>298,259,126.86</b>	<b>93.5</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>4,181,011,100.00</b>	<b>3,930,515,702.56</b>	<b>250,495,397.44</b>	<b>94.0</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>2,702,054,400.00</b>	<b>2,661,444,788.86</b>	<b>40,609,611.14</b>	<b>98.5</b>
210101	Үндсэн цалин	1,763,385,900.00	1,741,105,098.77	22,280,801.23	98.7
210102	Нэмэгдэл	651,366,100.00	636,364,614.97	15,001,485.03	97.7
210103	Унаа хоолны хөнгөлөлт	287,302,400.00	283,975,075.12	3,327,324.88	98.8
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>378,774,100.00</b>	<b>372,823,442.62</b>	<b>5,950,657.38</b>	<b>98.4</b>
210201	Тэтгэврийн даатгал	270,692,000.00	268,467,449.15	2,224,550.85	99.2
210202	Тэтгэмжийн даатгал	27,020,500.00	25,180,800.00	1,839,700.00	93.2
210203	ҮОМШӨ-ний даатгал	21,616,400.00	20,144,700.00	1,471,700.00	93.2
210204	Ажилгүйдлийн даатгал	5,404,100.00	5,036,200.00	367,900.00	93.2
210205	Эрүүл мэндийн даатгал	54,041,100.00	53,994,293.47	46,806.53	99.9
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>92,526,000.00</b>	<b>92,526,000.00</b>	-	<b>100.0</b>
210304	Байрны түрээс	92,526,000.00	92,526,000.00	-	100.0
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>73,056,100.00</b>	<b>72,095,100.00</b>	<b>961,000.00</b>	<b>98.7</b>
210401	Бичиг хэрэг	20,814,000.00	19,853,000.00	961,000.00	95.4
210402	Тээвэр, шатахуун	13,378,700.00	13,378,700.00	-	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	34,083,200.00	34,083,200.00	-	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,780,200.00	4,780,200.00	-	100.0
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,020,400.00</b>	<b>1,020,390.00</b>	<b>10.00</b>	<b>100.0</b>
210604	Урсгал засвар	1,020,400.00	1,020,390.00	10.00	100.0
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>14,709,500.00</b>	<b>14,709,491.00</b>	<b>9.00</b>	<b>100.0</b>
210701	Гадаад албан томилолт	2,702,800.00	2,702,800.00	-	100.0
210702	Дотоод албан томилолт	12,006,700.00	1,933,020.00	10,073,680.00	16.1
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	-	10,073,671.00	(10,073,671.00)	
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>913,220,300.00</b>	<b>710,246,190.08</b>	<b>202,974,109.92</b>	<b>77.8</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	679,867,100.00	523,558,269.18	156,308,830.82	77.0
210803	Даатгалын үйлчилгээ	4,661,300.00	4,661,300.00	-	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,000,000.00	1,000,000.00	-	100.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	128,500.00	128,500.00	-	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	107,345,000.00	107,345,000.00	-	100.0
210807	Газрын төлбөр	530,000.00	530,000.00	-	100.0
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	119,688,400.00	73,023,120.90	46,665,279.10	61.0

Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>5,650,300.00</b>	<b>5,650,300.00</b>	<b>-</b>	<b>100.0</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,650,300.00	5,650,300.00	-	100.0
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>386,533,700.00</b>	<b>338,769,970.58</b>	<b>47,763,729.42</b>	<b>87.6</b>
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	<b>279,246,000.00</b>	<b>279,246,000.00</b>	<b>-</b>	<b>100.0</b>
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	-	-	
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	279,246,000.00	279,246,000.00	-	100.0
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>107,287,700.00</b>	<b>59,523,970.58</b>	<b>47,763,729.42</b>	<b>55.5</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	94,206,700.00	46,442,970.58	47,763,729.42	49.3
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	13,081,000.00	13,081,000.00	-	100.0
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>4,567,544,800.00</b>	<b>4,269,285,673.14</b>	<b>298,259,126.86</b>	<b>93.5</b>
<b>31</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>2,858,443,600.00</b>	<b>2,463,053,743.71</b>	<b>395,389,856.29</b>	<b>86.2</b>
310001	Улсын төсвөөс санхүүжих	2,858,443,600.00	2,463,053,743.71	395,389,856.29	86.2
<b>35</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>1,709,101,200.00</b>	<b>1,806,231,929.43</b>	<b>(97,130,729.43)</b>	<b>105.7</b>
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,709,101,200.00	1,772,414,679.43	(63,313,479.43)	103.7
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	33,817,250.00	(33,817,250.00)	
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	14,511,488.70	(14,511,488.70)	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	19,902,288.70	(19,902,288.70)	
<b>49</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>				
<b>50</b>	<b>АЖИЛЧДЫН ТОО</b>	<b>154</b>	<b>142</b>	<b>12</b>	
51	Удирдах ажилтан	21	18	3	
52	Гүйцэтгэх ажилтан	133	124	9	
<b>53</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>154</b>	<b>142</b>	<b>12</b>	
54	Ажлын албаны албан хаагч (АА)	140	128	12	
55	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	11	11	-	
56	Улс төрийн албан хаагч (УТ)	3	3	-	

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ТЕЗ цэвэр дүн
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>494,555,430.28</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>494,555,430.28</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>355,619,509.28</b>
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>33,710,865.28</b>
210701	Гадаад албан томилолт	33,710,865.28
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>321,908,644.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	321,908,644.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>138,935,921.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>136,550,000.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	90,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	46,550,000.00
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>2,385,921.00</b>
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжил төвлөрүүлэх шилжүүлэг	2,385,921.00
<b>I</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>494,555,430.28</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>494,555,430.28</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	494,555,430.28
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,014.72
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,014.72

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Санхүүгийн зохицуулах хорооны даргын төсвийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд хөрөнгө эзэмших эрх, өр төлбөр төлөх үүргийн хэрэгжилтийг хангах, орлогын бүртгэл, дотоод хяналтыг сайжруулах, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Аудитын хоёрдугаар газрын аудитор Л.Мөнхцацрал гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер С.Нацагдорж, аудитын дөрөвдүгээр газрын захирал, тэргүүлэх аудитор Я.Самбууням, Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар хэрэгжүүлсэн.

Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2021 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 1/1214 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 310 дугаар тогтоолоор баталсан “Санхүүгийн зохицуулах хорооны үйл ажиллагааны стратеги 2018-2021”-д “Санхүүгийн зохистой бодлого, үр ашигтай хяналт шалгалт, оновчтой зохицуулалтыг хэрэгжүүлж олон тулгуурт, хэрэглэгчдийн эрхийг хамгаалсан, итгэлийг нэмэгдүүлсэн тогтвортой санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл, стратегийн зорилтоо дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах;
- Хөрөнгө оруулагч, харилцагч, даатгуулагчдын эрх ашгийг хамгаалах;
- Банкнаас бусад санхүүгийн зах зээл болон үл хөдлөх хөрөнгө зуучлалын байгууллагууд, үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдэд хяналт шалгалт хийх;
- Бодлого зохицуулалтын орчныг бүрдүүлэх.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Коронавируст халдварын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- ТӨБЗГ-ын 2020 оны “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 50 дугаар тогтоол;
- Засгийн газрын 2020 оны “Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай” 78, 114 дүгээр тогтоол.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэлийн үе шатанд хяналтын сорил

гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна гэж үзсэн.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн боловч тус байгууллагын үйл ажиллагааны орлогын бүртгэлийн орчил, онцлогт тохироогүй байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод аудитын нэгж тайлант онд санхүү, төсвийн төлөвлөлт, зарцуулалтад хяналт тавьж ажиллаагүй, төлөвлөгөө, гүйцэтгэлийн тайлан гаргаагүй байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, түүний хүлээн зөвшөөрөхүйц байдал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны санхүүгийн тайлан дахь үйл ажиллагааны орлогоос бусад ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлсөн, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн, хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг MNS 6817-4:2020 стандартын дагуу тодорхойлохдоо суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд ерөнхий материаллаг байдлын түвшинг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 5,342.1 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 53.4 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн үе шатанд төлөвлөлтийн шатанд тогтоосон материаллаг байдлын түвшнийг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн болно.

### 3.5 Санхүүгийн тайлангийн үзүүлэлт

Санхүүгийн зохицуулах хорооны даргын төсвийн төсвийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 47.6 сая төгрөгөөр буюу 2.7 хувиар өсөж 1,824.3 сая төгрөг болоход авлага, урьдчилгаа, бараа материал, үндсэн хөрөнгийн дансны өөрчлөлт нөлөөлсөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
			3=2-1
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	14.5	19.9	5.4
Авлага	77.3	7.2	(70.1)
Урьдчилгаа	310.6	200.6	(110.0)
Бараа материал	120.9	199.0	78.1
Үндсэн хөрөнгө	1,253.4	1,397.6	144.2
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,776.7</b>	<b>1,824.3</b>	<b>47.6</b>
Өр төлбөр	2.3	1.9	(0.4)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,774.4	1,822.4	48.0
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>1,776.7</b>	<b>1,824.3</b>	<b>47.6</b>

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 19.9 сая төгрөг болж 5.4 сая төгрөгөөр өссөн нь ахмадын сангийн нэмэлт санхүүжилтийн дансанд үйл ажиллагааны давсан орлогоос 10.0

сая төгрөг төвлөрүүлж, ахмадуудад хүндэтгэл үзүүлэхэд 4.6 сая төгрөгийг зарцуулсантай холбоотой байна.

Авлага дансны үлдэгдэл 7.2 сая төгрөг болж 70.1 сая төгрөгөөр буурсан нь Сангийн яамнаас авах татаас санхүүжилтийн авлага 58.4 сая төгрөг, байгууллага хувь хүнээс авах 10.2 сая төгрөг, ажиллагсадтай холбоотой 1.5 сая төгрөгийн авлагыг тус тус цуглуулж, хөрөнгийн эргэлт нэмэгдэн, санхүүгийн нөөцийн ашиглалт сайжирсан эерэг үр дүнтэй байна.

Урьдчилгаа дансны үлдэгдэл 200.6 сая төгрөг болж, 110.0 сая төгрөгөөр буурсан нь тайлант онд 321.7 сая төгрөгийн урьдчилгаа олгосон, 431.7 сая төгрөгийн хөрөнгө, ажил үйлчилгээний гэрээний гүйцэтгэлийг хангуулж, хүлээн авсантай холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 199.0 сая төгрөг болж 78.1 сая төгрөгөөр төгрөгөөр өссөн нь аж, ахуйн материал 41.2 сая, бичиг хэргийн материал 26.1 сая, хангамжийн материал 8.7 сая, түлш, шатах тослох материал 1.4 сая, бусад материал 0.7 сая төгрөгөөр өссөнөөс шалтгаалсан байна.

Энэ нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр иргэд, олон нийтийг мэдээ, мэдээллээр хангах, соён гэгээрүүлэх хуулийн чиг үүргийн хэрэгжилт, "Олон нийтийн санхүүгийн суурь боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр"-ийн хүрээнд богино хэмжээний анимейшн, видео, шторк, подкаст, гарын авлага, танилцуулга, санхүүгийн хүртээмжтэй сэтгүүл, тойм, санхүүгийн товхимол бэлтгэсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,397.6 сая төгрөг болж 144.2 сая төгрөгөөр өссөн нь 287.3 сая төгрөгийн хөрөнгийг /145.5 сая төгрөгийг үйл ажиллагааны давсан орлогоос, 141.8 сая төгрөгийг урсгал санхүүжилтээр/ худалдан авч, 29.1 сая төгрөгийн хөрөнгийг хандиваар бэлтгэн, ТӨБЗГ-ын 2020 оны 375 дугаар тогтоолын дагуу 19.7 сая төгрөгийн хөрөнгийг акталж устган, тайлант онд 152.5 сая төгрөгийн элэгдлийн зардал тооцсоноос шалтгаалсан байна.

Хөрөнгө нэмж бэлтгэсэн нь холбогдох хууль тогтоомжоор үйл ажиллагааны чиглэл нэмэгдсэнтэй холбоотойгоор шинэ бүтэц зохион байгуулалтын дагуу ажлын байранд шаардлагатай сандал ширээ, компьютер, тоног төхөөрөмж худалдан авсантай холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 1.8 сая төгрөг болж 0.4 сая төгрөгөөр буурсан нь хувь хүнд төлөх өглөгийг барагдуулсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,822.4 сая төгрөг болж 48.0 сая төгрөгөөр өссөн нь өмнөх онд зардлаар хүлээн зөвшөөрсөн мэдээллийн эх бэлтгэх ажлын зардлын 40.0 сая төгрөгийг хөрөнгөөр хүлээн зөвшөөрч, нягтлан бодох бүртгэлийн залруулгаар өмнөх оны үр дүнг өсгөсөн, мөн тайлант оны хуримтлагдсан үр дүн 8.0 сая төгрөгөөр нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 215.5 сая буюу 4.0 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт орсон нийтлэг татварын бус орлого, тусламж санхүүжилтийн орлого байна.

Татварын бус орлого 2,451.3 сая төгрөг болж 105.9 сая төгрөгөөр буурсан нь цар тахлын онцгой нөхцөл байдлын улмаас төсөвт байгууллагын өөрийн орлого 254.3 сая төгрөгөөр буурч, зохицуулалттай этгээдийн хуулийн хэрэгжилтийг хангуулах торгуулийн орлого 138.4 сая төгрөг, ахмадын сангийн мөнгөн орлого 10.0 сая төгрөгөөр өссөн нь нөлөөлжээ.

Тусламж, санхүүжилтийн орлого 2,858.0 сая төгрөг болж 85.7 сая төгрөгөөр буурсан нь урсгал үйл ажиллагааны санхүүжилт 38.6 сая төгрөгөөр, хандив, тусламжийн орлого 47.1 сая төгрөгөөр буурсантай холбоотой байна.

Орлогын бууралттай уялдаж нийт зардал 5,341.7 сая төгрөг болж, 241.9 сая төгрөгөөр буюу 4.3 хувиар буурахад хүргэжээ.



Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт бүхий цалин хөлс болон нэмэгдэл урамшил, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл, томиллолт, зочны болон урсгал шилжүүлгийн зардал байна.

Цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал 553.6 сая төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 79.8 сая төгрөг, эд хогшил, урсгал засварын зардал 15.9 сая төгрөгөөр өссөн нь хуулиар тус хорооны чиг үүрэгт өөрчлөлт орж, орон тоо нэмэгдсэнтэй холбоотой байна.

Томиллолт, зочны зардал 249.5 сая төгрөгөөр буурахад Коронавируст цар тахлын улмаас төлөвлөгдсөн гадаад томиллолтын зардал 163.6 сая төгрөг, дотоод албан томиллолт 70.4 сая төгрөг, зочин төлөөлөгч хүлээх авах зардал 15.5 сая төгрөг зарцуулагдаагүй нь нөлөөлжээ.

Урсгал шилжүүлэг 676.1 сая төгрөгөөр буурсан нь улсын төсвөөс олгосон санхүүжилт 702.8 сая төгрөгөөр буурч, бусад урсгал шилжүүлэг 23.0 сая төгрөг, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх тэмдэгтийн хураамжийн шилжүүлэг 3.7 сая төгрөгөөр өссөнтэй холбоотой байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн ерөнхийлөн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 9,266.7 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 1,100.0 сая төгрөгөөр, нийт зарлагыг 10,366.7 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлсэн байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн өргөн барьсан төсвийн төслийг хянаж батлахдаа төсвийн төслөөс 5,799.2 сая төгрөгөөр бууруулж 4,567.5 сая төгрөгөөр баталсан нь өмнөх оны төсвийн гүйцэтгэлд үндэслэн, төсвийн хэмнэлтийн бодлого баримталсантай холбоотой байна.

#### **Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 5 бүлэг хөтөлбөрийн 157 арга хэмжээг санхүүжүүлэхээр 4,567.5 сая төгрөгийн төсөв баталснаас 2,858.4 сая төгрөгийг улсын төсвөөс, 1,709.1 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 2,463.1 сая төгрөг, төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас 1,806.2 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 4,269.3 сая төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 4,269.3 сая төгрөг буюу 93.5 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлаас 40.6 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас 203.0 сая төгрөг, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмжийн зардлаас 47.8 сая төгрөг, хангамж бараа материалын зардлаас 0.9 сая төгрөг зарцуулагдаагүй үлдсэнтэй холбоотой байна.

Төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулахад Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай, Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр 2020 онд төлөвлөсөн арга хэмжээнээс зарим ажлууд цаг үеийн болон коронавируст халдварт цар тахлын улмаас хэрэгжих боломжгүйд хүрсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд Санхүүгийн хүртээмжийн нийгэмлэгээс 18.7 сая төгрөг, “Ногоон санхүүжилтийг нэвтрүүлэх төсөл”-өөс 138.1 сая төгрөг, татаас санхүүжилтийн авлагаас 50.0 сая төгрөг, 2020 оны үйл ажиллагааны давсан орлогоос зарцуулах эрх нээлгэж 287.7 сая төгрөг, нийт 494.5 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс албан томилолтод 33.7 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамжид 321.9 сая төгрөг, тэтгэмж урамшуулалд 90.0 сая төгрөг, нэг удаагийн тэтгэмж урамшуулалд 46.6 сая төгрөг тус тус зарцуулж, үлдэгдэл 2.3 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлж, татаас санхүүжилтийн авлагаар бүртгэсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Олон улсын санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага буюу ФАТФ –аас өгсөн үүргийн дагуу Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулиудад нэмэлт өөрчлөлт орж, хууль эрх зүйн шинэчлэл, үндэсний эрсдэлийн үнэлгээ, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа, олон нийтэд мэдээлэл түгээх гэсэн 4 чиглэлээр арга хэмжээг зохион байгуулж, амжилттай хэрэгжүүлсэн байна.

Эдгээр арга хэмжээг хэрэгжүүлснээр 2020 оны 10 дугаар сарын 23-ны өдөр ФАТФ-ын нэгдсэн хуралдаанаар Монгол Улсыг “Стратегийн дутагдалтай улс орон”-ы жагсаалтаас, 2020 оны 12 дугаар 09-ний өдөр Европын холбооны “Хар жагсаалт”-аас гарахад чухал үүрэг гүйцэтгэсэн нь тайлант оны онцлох үйл явдал байна.

Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны “Ажлын албаны бүтэц, нэгжийг батлах тухай” 78 дугаар тогтоолоор орон нутаг дахь төлөөлөгчтэй байхаар баталсан боловч орон тоог тусгаагүй байна.

Орон нутаг дахь төлөөлөгчийн үүргийг нийслэл, 21 аймгийн Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга нар гүйцэтгэж, хавсран ажилласан цалин хөлсийг Сангийн сайдын төсвийн багцын төсөвт тусган олгож байгаа нь төлөөлөгчдийн үүргийн биелэлтэд хяналт тавих, нэгдсэн удирдлагаар хангах, гүйцэтгэлд суурилсан цалингийн тогтолцоог бүрдүүлэх нөхцөлгүй, орон нутагт байрлах санхүүгийн салбарын хяналт, зохицуулалтыг үр нөлөөтэй хэрэгжүүлж байгаа эсэх нь тодорхойгүй байна.

### **3.8 Аудитын гол асуудал**

Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөгөөр 3 бүлэг 107 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс бодлогын баримт бичигт тусгагдсан 83 зорилт, арга хэмжээний гүйцэтгэл 84.3 хувь, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах 10 зорилт, арга хэмжээний хэрэгжилт 95.0 хувь, хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээний хэрэгжилт 14.0 хувь, нийт хэрэгжилт дунджаар 90.2 хувийн гүйцэтгэлтэй байна.

Тайлант онд чиг үүргийн хүрээнд 3260 зохицуулалттай этгээд, 2473 даатгалын төлөөлөгч, нийт 5733 иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд санхүүгийн зохицуулалт, хяналт хийж ажилласан байна.



Монгол Улсын хэмжээнд 2020 оны байдлаар хөрөнгийн зах зээлд ХК 315, мэргэжлийн оролцогчид 276, даатгалын зах зээлд нийт 319 компани, мэргэжлийн оролцогчид, аудитор, банк бус санхүүгийн 532 байгууллага, хадгаламж зээлийн 249 хоршоо, үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын 167 байгууллага, үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэгч 429 хувь хүн, хуулийн этгээд, тэдгээрийн 973 салбар тус тус үйл ажиллагаа явуулж байна.

### **3.9 Шилэн дансны мэдээлэл**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 235 мэдээллээс 191 мэдээллийг хугацаанд нь, 40 мэдээллийг хугацаа хоцроож, Худалдан авах ажиллагааны тайлан, тайлант онд авсан хандив тусламжийн хэмжээ, түүний зарцуулалтын тайлан, 2020 оны хагас, бүтэн жилийн санхүүгийн тайлан, давсан орлогоос олгосон 90.0 сая төгрөгийн шагнал урамшуулал зэрэг 4 мэдээллийг шилэн дансанд байршуулаагүй байна.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 63.7 сая төгрөгийн алдаа, зөрчилд 6 зөвлөмж өгснөөс 55.2 сая төгрөг буюу 86.7 хувийг хэрэгжүүлсэн гүйцэтгэлтэй байна. Урьдчилж төлсөн гэрээт ажлын гүйцэтгэлийг хангуулах тухай зөвлөмжийн хэрэгжилт 31.5 сая төгрөгөөр дутуу биелэгдсэн байна.

### **3.11 БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД**

Дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахлын улмаас аудитыг цахимаар хийж байгаагаас шалтгаалан, байгууллага дээр ажиллаж нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэх, анхан шатны баримт материалуудыг хамруулах болон төсвийн хяналтыг бүрэн хэрэгжүүлэх нөхцөл байдал хязгаарлагдмал байсан тул Санхүүгийн зохицуулах хорооны үйл ажиллагааны орлогыг, зохицуулалттай этгээдийн орлогын дансны хуулгатай тулган шалгах ажлыг дараагийн тайлант хугацаанд анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр иргэд, олон нийтийг мэдээ, мэдээллээр хангах, соён гэгээрүүлэх ажлын хүрээнд 2020 оны эцсээр бэлтгэсэн бараа материалын эргэц, ашиглалтад хяналт хэрэгжүүлэх нь зүйтэй байна.

Биет бус хөрөнгөд бүртгэлтэй 21.1 сая төгрөгийн 0141732 дугаартай улсын бүртгэлийн гэрчилгээтэй эзэмшлийн газрыг Монголбанкны 624 мкв талбай бүхий газартай нэгтгэж барилга барих, ашиглах, хамтран ажиллах 0217/346 СБ17/02 тоот гэрээг 2017 онд Монголбанкт байгуулсан байна.

Хамтран ажиллах гэрээнд тусгагдсан “Үндэсний цахим гүйлгээний төв”-ийн барилга 2020 оны эцсээр ашиглалтад орж, хороо нь барилгын 3 дугаар давхрын 742.5 м.кв талбайг үнэ төлбөргүйгээр, 4 дүгээр давхрын 742.5 м.кв талбайг 1,000.0 сая төгрөгийн өртгөөр, санхүүгийн түрээсийн хэлбэрээр төлбөрийг барагдуулах 03-03-0221/62 тоот гэрээг 2021 оны 02 дугаар сарын 04-ний өдөр Монголбанкт байгуулж, ашиглаж эхэлсэн байна.

Уг барилгатай холбоотой баримтууд барилгын захиалагч тал болох Монголбанканд байгаа тул Санхүүгийн зохицуулах хорооны болон уг барилгын талаарх асуудлыг аудитын хугацаанд хамруулах боломжгүй байсан нь анхаарал татах асуудал байна.

Үл хөдлөх хөрөнгө захиалж, бэлтгэсэн дээрх асуудлыг гүйцэтгэлийн аудитын хөрөнгө оруулалтын аудитад хамруулан шалгах нь зүйтэй байна.

### 3.12. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 50.4 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлснээс 20.4 сая төгрөгийн алдааг залруулж, 5.9 сая төгрөгийн 5 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 24.1 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 5 зөвлөмж өглөө.

#### Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- Үндсэн хөрөнгийг данснаас хассанаас үүссэн 19.7 сая төгрөгийн зардлыг ангилал зөрүүлэн элэгдлийн зардалд бүртгэсэн нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын холбогдох заалттай нийцэхгүй байна.
- Бараа материалын дансны үлдэгдэл, тодруулга тайлангийн дүнгээс 0.7 сая төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн бүртгэлийн алдааг аудитын явцад залруулав.

#### Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар илэрсэн 5.9 сая төгрөгийн 5 алдаа, зөрчилд албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

#### Албан шаардлага

1. Урьдчилгаа дансны үлдэгдэлд байгаа санхүүгийн салбарын эрсдэлийн үнэлгээний систем хөгжүүлэхэд 2018 онд олгосон 119.9 сая төгрөг, сургалт зохион байгуулах ажилд 2019 онд олгосон 41.2 сая төгрөгийн урьдчилж төлсөн төлбөрийн гүйцэтгэлийг тус тус хангуулаагүй, ажил гүйцэтгэх гэрээний хугацааг он дамжуулан сунгасан нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3-т “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах”, 40 дүгээр зүйлийн 40.4.1-д “төсвийн үр дүнг сайжруулах, хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар үүрэг өгч, хяналт тавьж ажиллах”, 41 дүгээр зүйлийн 41.2-т “Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ”, 41.2.7-д “хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах” гэж тус тус заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх

2. Хувь хүмүүст олгосон гэрээт ажлын хөлснөөс 5.9 сая төгрөгийн ХХОАТ суутгаагүй нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-т “Албан татвар төлөгчийн дараах орлогод албан татвар ногдоно: 6.3.1-д “цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого”, 25 дугаар зүйлийн 25.4-т “Суутган төлөгч нь хувь хүнд орлого олгох бүрдээ түүний албан татвар төлөгчийн дугаар болон хувь хүн тус бүрээр олгосон орлого, түүнд ногдуулан суутгасан албан татварын хэмжээний мэдээллийг цахимаар, эсхүл хувь хүний орлого, татварын бүртгэлийн дэвтэрт тэмдэглэж, харьяа татварын албанд улирал тутам өссөн дүнгээр гаргаж илгээнэ” гэсэн заалттай нийцэхгүй, тодруулга ба толилуулга, эрх ба үүрэг, үнэн зөв батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх

3. Холбогдох байгууллагын шийдвэргүйгээр үйл ажиллагааны давсан орлогоос 145.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэн, урсгал зардлын төсвөөс 33.1 сая төгрөгийн тавилга, эд хогшил, 75.8 сая төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авахаар төлөвлөж, хэрэгжүүлсэн нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 4-т “төрийн өмчит эрдэм шинжилгээний байгууллага, их, дээд сургууль дэргэдээ бие даасан

гарааны компани байгуулахаас бусад тохиолдолд үндсэн хөрөнгөд хамаарах эд хөрөнгө олж авах, захиалах, данснаас хасаж шилжүүлэх, устгах саналаа төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад тавьж, энэ хуулиар тогтоосон журмын дагуу зөвшөөрөл авах", Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 2-д "Журам батлагдсантай холбогдуулан дор дурдсан арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргад үүрэг болгосугай: 2.4-т." Төсөвт байгууллага нь нэмэлт төсөв, давсан орлого, холбогдох төсөл арга хэмжээний хүрээнд компьютер, дагалдах хэрэгсэл, тавилга эд хогшил, програм хангамж худалдан авах тохиолдолд төсөв зарцуулах эрх бүхий байгууллагын шийдвэрийг үндэслэн зөвшөөрөл олгож байх" гэсэн заалтыг мөрдлөг болгоогүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх

4. Урсгал зардлын төсвөөс 33.1 сая төгрөгийн тавилга, эд хогшил, 75.8 сая төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авахаар төлөвлөж, хэрэгжүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.4-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд тухайн төсөв хэрэгжих жил болон дунд хугацаанд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын арга хэмжээг жилийн төсвийн хязгаарт багтаан санхүүжилтийн бүх төрлийн эх үүсвэртэй нь уялдуулан боловсруулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 42 дугаар зүйлийн 42.7-д "Төсөвт зохицуулалт хийхдээ хөрөнгийн болон урсгал зардлыг хооронд нь шилжүүлэх, төсөвт тусгагдаагүй шинэ хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхийг хориглоно" гэж заасантай тус тус нийцэхгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх

5. Худалдан авах ажиллагааны тайлан, хандив тусламжаар авсан 159.9 сая төгрөгийн хөрөнгө, давсан орлогоос зарцуулсан 90.0 сая төгрөгийн шагнал урамшуулал, 2020 оны хагас, бүтэн жилийн санхүүгийн тайлан зэрэг мэдээллийг шилэн дансанд байршуулаагүй, нийт 40 мэдээллийг хуулийн хугацаанаас хоцроож мэдээлсэн нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ", 6.1.3-т "дараа жилийн төсвийн төслийг жил бүрийн 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор", 6.1.4-т "жилийн эцсийн санхүүгийн тайланг дараа жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, хагас жилийн тайланг 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор", 6.3.5-д "хандив, тусламжийн хэмжээ, түүний зарцуулалт", 6.3.4-т "өмнөх оны төсвийн зарлагын хэмнэлт, туслах үйл ажиллагааны орлогын давсан хэсгийг урамшуулалд зарцуулсан бол зориулалтыг заасан байх" гэж заасантай тус тус нийцэхгүй, эрх ба үүрэг, тодруулга ба толилуулга батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх

**Аудитын зөвлөмж**

Аудитаар илэрсэн 24.1 сая төгрөгийн алдаа, зөрчилд 5 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

#### 4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

##### 1. Авлага, өглөгийн данстай холбоотой асуудал

###### 1.1. Илрүүлэлт:

Дээд шүүхийн шийдвэрээр хариуцуулсан 923.4 сая төгрөгийн төлбөрийг санхүүгийн тайланд өглөгөөр тусгаж бүртгээгүй, барагдуулах эх үүсвэрийг шийдвэрлэх үр дүнтэй арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2-т "санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ" 14.4.3-т: "бүх өр төлбөр" гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг, тодруулга ба толилуулга батламж мэдэгдлийг хангахгүй байна.

###### 1.2. Өгсөн зөвлөмж:

Хуулийн байгууллагаар төлүүлэхээр хариуцуулсан өр төлбөрийг санхүүгийн тайланд тусгаж, төсөвт дарамт учруулахгүйгээр жил бүрийн давсан орлогоос хуваарь гарган төлж барагдуулах арга хэмжээ авах

##### 2. Үл хөдлөх хөрөнгөтэй холбоотой асуудал

###### 2.1. Илрүүлэлт:

Биет бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй 653 м.кв талбай бүхий 21.2 сая төгрөгийн дансны үнэ бүхий газарт хөрөнгө захиалах, бэлтгэх тухай эрх бүхий байгууллагын шийдвэргүйгээр Монголбанкны хөрөнгөөр барилга бариулж, барилгын талбайгаас 1 давхрын талбайг үнэ төлбөргүй өмчлөхөөр гэрээ хийж, үл хөдлөх хөрөнгө захиалж бэлтгэсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 4-т "төрийн өмчит эрдэм шинжилгээний байгууллага, их, дээд сургууль дэргэдээ бие даасан гарааны компани байгуулахаас бусад тохиолдолд үндсэн хөрөнгөд хамаарах эд хөрөнгө олж авах, захиалах, данснаас хасаж шилжүүлэх, устгах саналаа төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад тавьж, энэ хуулиар тогтоосон журмын дагуу зөвшөөрөл авах", 30 дугаар зүйлийн 3-т "Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр хандивлах, бэлэглэх, барьцаалах, зээлдүүлэх, бусад өмчийн хуулийн этгээдэд хувь хөрөнгө болгон оруулахыг хориглоно", Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйл дэх: "Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний бүрэн эрх"-ийн "14.2.4-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд тухайн төсөв хэрэгжих жил болон дунд хугацаанд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын арга хэмжээг жилийн төсвийн хязгаарт багтаан санхүүжилтийн бүх төрлийн эх үүсвэртэй нь уялдуулан боловсруулах", Газрын тухай хуулийн 35 дугаар зүйл: "Газар эзэмшигчийн эрх, үүрэг"-ийн 35.1.4-т "газар эзэмшүүлэх тухай шийдвэр гаргасан этгээдийн зөвшөөрөлтэйгээр эрхийн гэрчилгээгээ бусдад шилжүүлэх", 35.1.6-д "газар эзэмшигч нь газар эзэмшүүлэх тухай шийдвэр гаргасан этгээдийн зөвшөөрөлтэйгээр тухайн газраа бүгдийг нь буюу зарим хэсгийг бусдад ашиглуулж болно", 35.2-т "Энэ хуулийн 35.1.4, 35.1.6-д заасан эрх төрийн байгууллагад хамаарахгүй" гэж заасантай тус тус нийцэхгүй, эрх ба үүрэг, иж бүрэн байх, толилуулга ба тодруулга, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

###### 2.3. Өгсөн зөвлөмж:

Хөрөнгө бэлтгэх, захиалах, өмчлөх талаар эрх бүхий байгууллагын шийдвэр гаргуулах, үл хөдлөх хөрөнгийг бүртгэх, тайлагнах, эх үүсвэрийг хууль эрх зүйн хүрээнд төлөвлөж, батлуулах талаар Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хандаж, шийдвэрлэх

### *3. Орлогын бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал*

#### 3.1. Илрүүлэлт:

Зохицуулах үйлчилгээний төвлөрүүлэх орлогыг гүйцэтгэлээр буюу мөнгөн сууриар бүртгэсэн, Хяналт шалгалт, зохицуулалтын газар ба Санхүү хөрөнгө оруулалтын албаны орлогын ногдуулалт, бүртгэлтэй холбоотой ажлын уялдаа болон бүртгэлд тавих дотоод хяналт сул байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д "Төсвийн байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу бүрэн аккруэл суурьтай нягтлан бодох бүртгэл хөтөлнө", Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын 2.2-т "Ажил үйлчилгээ (нийлүүлсэн бүтээгдэхүүн)-ний орлогыг аккруэл суурьт үндэслэн тайлант хугацааны туршид хуримтлуулан бүртгэнэ. Хэрэглэгчдэд ажил үйлчилгээ үзүүлсэн, бараа бүтээгдэхүүнийг худалдан авагчдад шилжүүлсэн үед орлогыг хүлээн зөвшөөрч бүртгэнэ", 2.3-т "Орлогыг анх хүлээн авсан буюу авлага болгон тооцсон дүнгээр хэмжиж тодорхойлно" гэж заасантай тус тус нийцэхгүй, тодруулга ба толилуулга, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

#### 3.2 Өгсөн зөвлөмж:

Орлогыг аккруэл сууриар бүртгэх, дотоод нэгжүүдийн орлогын ногдуулалт, бүрдүүлэлттэй холбоотой ажлын уялдааг сайжруулан дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх

### *4. Хуулиар хүлээсэн үүргийн хэрэгжилтийн талаар*

#### 4.1 Илрүүлэлт:

Санхүүгийн зохицуулах хороонд бүртгэлтэй, хөрөнгө оруулалтын менежментийн компаниудын үйл ажиллагааны мэдээ, мэдээллээ тогтоосон хугацаанд ирүүлэх үүргийн хэрэгжилт 57.6 хувьтай, Хөдөө, аж ахуйн биржүүдийн хэрэгжилт 50.0 хувийн гүйцэтгэлтэй байгаа нь Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйл дэх "Хорооны бүрэн эрх"-ийн 6.1.1-д "санхүүгийн үйлчилгээтэй холбоотой хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, биелэлтэд нь хяналт тавих" гэсэн заалтын хэрэгжилт хангалтгүй, Санхүүгийн зохицуулах хорооны дүрмийн 2 дугаар зүйлийн 2.2.2-т "санхүүгийн зах зээлд үйл ажиллагаа явуулж байгаа банк бус санхүүгийн байгууллага, үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллага, хувьцаат компани, даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогч, хадгаламж зээлийн хоршоо, тэдгээрийн хөрөнгө оруулагч, даатгуулагч, хадгаламж эзэмшигч, үйлчлүүлэгч болон холбогдох бусад иргэн, хуулийн этгээдээс тэдгээрийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагааны тайлан, тодорхойлолт, мэдээ авах" гэж заасантай тус тус нийцэхгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

#### 4.2 Өгсөн зөвлөмж:

Хорооны санхүүгийн үйлчилгээтэй холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, биелэлтэд нь хяналт тавих, зохицуулалттай этгээдэд тавих хяналтыг эрчимжүүлэх талаар арга хэмжээ авах

### *5. Авлага, өглөгийн дансны талаар*

#### 5.1 Илрүүлэлт:

Эргэн төлөлт удааширсан, насжилт өндөр 2.0 сая төгрөгийн өглөг, 0.9 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх"; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг

дараах тохиолдолд заавал хийнэ: 12.2.1-д “жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө” гэж заасантай тус тус нийцэхгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**5.3. Өгсөн зөвлөмж:**

Авллага, өглөгийг барагдуулах, жилийн эцэст тулган баталгаажуулж байх

Дээрх зөвлөмжүүдийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2021 оны 09 дүгээр сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Хавсралт

Огноо:	Аудитын нэр:	<b>Санхүүгийн зохицуулах хорооны даргын төсвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит</b>	Аудитын код:
2021			САГ-2021/15/СТА-ТЕЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	<b>Санхүүгийн зохицуулах хороо</b>		Сая төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Урьдчилгаа дансны үлдэгдэлд байгаа санхүүгийн салбарын эрсдэлийн үнэлгээний систем шинээр хөгжүүлэхэд 2018 онд олгосон 119.9 сая, сургалт зохион байгуулах ажилд 2019 онд төлсөн 41.2 сая төгрөгийн гүйцэтгэлийг хангуулаагүй, ажил гүйцэтгэх гэрээний хугацааг он дамжуулан сунгасан байна.		Албан шаардлага	Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын албаны дарга, Ерөнхий нягтлан бодогч	Т.Жамбаажамц; Б.Нансалмаа
2	Эргэн төлөлт удааширсан, насжилт өндөртэй 2.0 сая төгрөгийн өглөг, 0.9 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй	2.9	Зөвлөмж	Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын албаны дарга, Ерөнхий нягтлан бодогч	Т.Жамбаажамц; Б.Нансалмаа
3	Дээд шүүхийн шийдвэрээр хариуцуулсан 923.4 сая төгрөгийн төлбөрийг барагдуулах эх үүсвэрийг шийдвэрлэх арга хэмжээ аваагүй, санхүүгийн тайланд өглөгөөр тусгаж бүртгээгүй байна.		Зөвлөмж	Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын албаны дарга, Ерөнхий нягтлан бодогч	Т.Жамбаажамц; Б.Нансалмаа
4	Зохицуулах үйлчилгээний төвлөрүүлэх орлогыг гүйцэтгэлээр буюу мөнгөн сууриар бүртгэсэн, Хяналт шинжилгээ үнэлгээний газар ба Санхүү хөрөнгө оруулалтын албаны орлогын ногдуулалт, бүртгэлтэй холбоотой ажлын уялдаа, орлогын бүртгэлд тавих дотоод хяналт сул байна.		Зөвлөмж	Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын албаны дарга, Ерөнхий нягтлан бодогч	Т.Жамбаажамц; Б.Нансалмаа
5	Урсгал зардлын төсвөөс 33.1 сая төгрөгийн тавилга, эд хогшил, 75.8 сая төгрөгийн тоног төхөөрөмж худалдан		Албан шаардлага	Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын албаны дарга,	Т.Жамбаажамц; Б.Нансалмаа

	авахаар төлөвлөж, хэрэгжүүлсэн.			Ерөнхий нягтлан бодогч	
6	Гэрээт ажлын хөлснөөс 5.9 сая төгрөгийн ХХОАТ суутгаагүй	5.9	Албан шаардлага	Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын албаны дарга, Ерөнхий нягтлан бодогч	Т.Жамбаажамц; Б.Нансалмаа
7	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын шийдвэргүйгээр үйл ажиллагааны давсан орлогоос 145.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэн		Албан шаардлага	Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын албаны дарга, Ерөнхий нягтлан бодогч	Т.Жамбаажамц; Б.Нансалмаа
8	Худалдан авах ажиллагааны тайлан, тайлант онд авсан хандив тусламжийн хэмжээ, түүний зарцуулалтын тайлан, 2020 оны хагас, бүтэн жилийн санхүүгийн тайлан, давсан орлогоос олгосон шагнал урамшуулал зэрэг мэдээллийг шилэн дансанд байршуулаагүй, нийт 40 мэдээллийг хуулийн хугацаанаас хоцроож мэдээлсэн		Албан шаардлага	Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын албаны дарга, Ерөнхий нягтлан бодогч	Т.Жамбаажамц; Б.Нансалмаа
9	21.2 сая төгрөгийн дансны үнэ, 653 кв талбай бүхий хорооны эзэмшлийн газар дээр эрх бүхий байгууллагын шийдвэр, хөрөнгө оруулалтын батлагдсан төсөвгүйгээр Монгол банкны хөрөнгөөр барилга бариулж, барилгын талбайгаас 1 давхрын талбайг үнэ төлбөргүйгээр үл хөдлөх хөрөнгө захиалж, бэлтгэсэн байна.	21.2	Зөвлөмж	Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын албаны дарга, Ерөнхий нягтлан бодогч	Т.Жамбаажамц; Б.Нансалмаа
10	Хөрөнгө оруулалтын менежментийн компаниудын үйл ажиллагааны мэдээ, мэдээллээ тогтоосон хугацаанд ирүүлэх үүргийн хэрэгжилт 57.6 хувь, Хөдөө, аж ахуйн биржүүдийн хэрэгжилт 50.0 хувьтай,		Зөвлөмж	Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын албаны дарга, Ерөнхий нягтлан бодогч	Т.Жамбаажамц; Б.Нансалмаа
ДҮН		30.0			





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 04 дугаар сарын 26

№ 549/А0110001  
САГ-2021/15/СТА-ТЭЗ

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Санхүүгийн хорооны хорооны 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Холбогдох байгууллагын шийдвэргүйгээр үйл ажиллагааны давсан орлогоос 145.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "төрийн өмчит эрдэм шинжилгээний байгууллага, их, дээд сургууль дэргэдээ бие даасан гарааны компани байгуулахаас бусад тохиолдолд үндсэн хөрөнгөд хамаарах эд хөрөнгө олж авах, захиалах, данснаас хасаж шилжүүлэх, устгах саналаа төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад тавьж, энэ хуулиар тогтоосон журмын дагуу зөвшөөрөл авах", Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасаж, шилжүүлэх журам"-ын 2-д "Журам батлагдсантай холбогдуулан дор дурдсан арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Төрийн бодлого, зохицуулалтын газрын даргад үүрэг болгосугай: 2.4-т Төсөвт байгууллага нь нэмэлт төсөв, давсан орлого, холбогдох төсөл арга хэмжээний хүрээнд компьютер, дагалдах хэрэгсэл, тавилга эд хогшил, программ хангамж худалдан авах тохиолдолд төсөв зарцуулах эрх бүхий байгууллагын шийдвэрийг үндэслэн зөвшөөрөл олгож байх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь**.

1. Холбогдох байгууллагын шийдвэргүйгээр давсан орлогоос хөрөнгө бэлтгэсэн дээрх алдаа зөрчлийг арилгаж, биелэлтийг 2021 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан, Ажлын албаны дарга Т.Жамбаажамц, Санхүү, хөрөнгө оруулалтын албаны дарга, ерөнхий нягтлан бодогч Б.Нансалмаа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР

Д.ЗАНДАНБАТ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,  
Утас 51-264230

10.10.10.20 Bichig\_Khureg\_Alban\_Shaardlaga\_2021\_0426auditin\_2-R\_Gazar16.Docx

001081256



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 04 дугаар сарын 26

№ 548/АОИ10001

Улаанбаатар хот

САГ-2021/15/СТА-ТЕЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хувь хүмүүст олгосон гэрээт ажлын хөлснөөс 5.9 сая төгрөгийн ХХОАТ суутгаагүй байна.

Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-т "Албан татвар төлөгчийн дараах орлогод албан татвар ногдоно: 6.3.1-т "цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого", 25 дугаар зүйлийн 25.4-д "Суутган төлөгч нь хувь хүнд орлого олгох бүрдээ түүний албан татвар төлөгчийн дугаар болон хувь хүн тус бүрээр олгосон орлого, түүнд ногдуулан суутгасан албан татварын хэмжээний мэдээллийг цахимаар, эсхүл хувь хүний орлого, татварын бүртгэлийн дэвтэрт тэмдэглэж, харьяа татварын албанд улирал тутам өссөн дүнгээр гаргаж илгээнэ" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол албаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Суутган тооцоогүй орлогын албан татварын зөрчлийг арилгаж, биелэлтийг 2021 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан, Ажлын албаны дарга Т.Жамбаажамц, Санхүү, хөрөнгө оруулалтын албаны дарга, ерөнхий нягтлан бодогч Б.Нансалмаа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР

Д.ЗАНДАНБАТ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй оүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

©10.10.10 20-Bichig\_Khereg\Alban-Shaardlaga\2021\0426auditin 2-R Gazar\4 Docx

001081253





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 04 дугаар сарын 26

№ 550/А0110001

Улаанбаатар хот

САГ-2021/15/СТА-ТЭЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Худалдан авах ажиллагааны тайлан, хандив тусламжаар авсан 159.9 сая төгрөгийн хөрөнгө, давсан орлогоос зарцуулсан 90.0 сая төгрөгийн шагнал урамшуулал, 2020 оны хагас, бүтэн жилийн санхүүгийн тайлан зэрэг мэдээллийг шилэн дансанд байршуулаагүй, нийт 40 мэдээллийг хуулийн хугацаанаас хоцроож мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ”, 6.1.3-т “дараа жилийн төсвийн төслийг жил бүрийн 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор”, 6.1.4-т “жилийн эцсийн санхүүгийн тайланг дараа жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, хагас жилийн тайланг 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор”, 6.3.5-д “хандив, тусламжийн хэмжээ, түүний зарцуулалт”, 6.3.4-т “өмнөх оны төсвийн зарлагын хэмнэлт, туслах үйл ажиллагааны орлогын давсан хэсгийг урамшуулалд зарцуулсан бол зориулалтыг заасан байх” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, мэдээллийн ил тод байдлыг хангаж ажиллах, биелэлтийг 2021 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан, Ажлын албаны дарга Т.Жамбаажамц, Санхүү, хөрөнгө оруулалтын албаны дарга, ерөнхий нягтлан бодогч Б.Нансалмаа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР

Д.ЗАНДАНБАТ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй оүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

10.10.10.20 Bichig\_Kherэг Албан Шаардлага 2021 0426auditin 2-R Газар18.Docx

001081261



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 04 дугаар сарын 26

№ 551/АОН0001

Улаанбаатар хот

САГ-2021/15/СТА-ТЭЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Урьдчилгаа дансны үлдэгдэлд байгаа санхүүгийн салбарын эрсдэлийн үнэлгээний систем хөгжүүлэхэд 2018 онд олгосон 119.9 сая төгрөг, сургалт зохион байгуулах ажилд 2019 онд олгосон 41.2 сая төгрөгийн урьдчилж төлсөн төлбөрийн гүйцэтгэлийг тус тус хангуулаагүй, ажил гүйцэтгэх гэрээний хугацааг он дамжуулан сунгасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", 40 дүгээр зүйлийн 40.4.1-т "төсвийн үр дүнг сайжруулах, хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар үүрэг өгч, хяналт тавьж ажиллах", 41 дүгээр зүйлийн 41.2-т "Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ", 41.2.7-д хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-д заасныг үндэслэн

**ШААРДАХ нь:**

1. Гэрээний үүргийг хангуулахтай холбоотой дээрх алдаа, зөрчлийг арилгаж, биелэлтийг 2021 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан, Ажлын албаны дарга Т.Жамбаажамц, Санхүү, хөрөнгө оруулалтын албаны дарга, ерөнхий нягтлан бодогч Б.Нансалмаа нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР



Д.ЗАНДАНБАТ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,  
Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig\_Kherem\Alban\_Shaardlaga\2021\0426auditin 2-R\_Gazar13.Docx

001081250





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 04 дугаар сарын 26

№ 552/20110001

Улаанбаатар хот

САГ-2021/15/СТА-ТЭЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Урсгал зардлын төсвөөс 33.1 сая төгрөгийн тавилга, эд хогшил, 75.8 сая төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авахаар төлөвлөж, хэрэгжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.4-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд тухайн төсөв хэрэгжих жил болон дунд хугацаанд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын арга хэмжээг жилийн төсвийн хязгаарт багтаан санхүүжилтийн бүх төрлийн эх үүсвэртэй нь уялдуулан боловсруулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 42 дугаар зүйлийн 42.7-д "Төсөвт зохицуулалт хийхдээ хөрөнгийн болон урсгал зардлыг хооронд нь шилжүүлэх, төсөвт тусгагдаагүй шинэ хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхийг хориглоно" гэж заасантай тус тус нийцэхгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Урсгал төсвийн зардлаас хөрөнгө бэлтгэсэн дээрх алдаа зөрчлийг арилгаж, биелэлтийг 2021 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан, Ажлын албаны дарга Т.Жамбаажамц, Санхүү, хөрөнгө оруулалтын албаны дарга, ерөнхий нягтлан бодогч Б.Нансалмаа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР

Д.ЗАНДАНБАТ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

10.10.10.20\Bichig\_Kherig\Alban\_Shaardlaga\2021\0426auditin\_2-R\_Gazar\7.Docx

001081259